- Хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, нэгдсэн бодлого, стратеги төлөвлөгөог боловсруулан, байгууллагын түвшний эрсдэлийн удирдлагын тогтолцоог гарган ирэхийн тулд ажиллаж байгаа;

- Гадаад орнуудын туршлагыг судалж, өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн, Хөрш болон Цагдаа, Тагнуул. Гаалийн байгууллагуудтай зөрчлийн мэдээлэл солилцох гм.

- Зөрчлийн мэдээллийн нэгдсэн цахим сантай болж, түүндээ эрсдэл тооцон ажилласан;

- Төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх гэх мэт.

**Дэвшүүлэх санал:**

- Гүйцэтгэх ажлыг эрчимжүүлэх, хил хамгаалах байгууллагад гүᴦйцэтгэх ажил явуулах эрхийг буцаан сэргээснээр сүүлийн үед гарч буй гэмт хэрэг, хилийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэлт нэмэгдэх

- Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх оновчтой бодлогыг тууштай хэрэгжүүлж, хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, шаардлагатай хөрөнгө мөнгө, тоног төхөөрөмжийг шийдэн, хар тамхитай тэмцэх чиглэлээр мэргэшсэн боловсон хүчинг бэлтгэх, чадварлаг багийг бий болгох.

**Г.Цогбадрах** - *Хуулъ сахиулахын удирдлагын академийн 8021 дүгээр дамжааны суралцагч, дэд хурандаа*
**Я.Ариунболд** - *Хилийн албаны удирдлага, стратпегийн профессорын багийн профессор, хурандаа*

## ХИЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН АЛБАНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

***Хураангуй.*** *Энэхүү илтгэлээр Монгол Улсын Хилийн төлөөлөгч, түүний үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, цаашид хилийн төлөөлөгчийн албаны удирдлага, зохион байгуулалтад анхаарах зарим асуудлын талаар хөндөхийг зорьсон болно.*

***Түлхүүр** үг. Хилийн төлөөлөгч, эрх зүйн үндэс, удирдлага, зохион байгуулалт, тулгамдсан асуудал.*

Хилийн төлөөлөгч гэдэг нь хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг улсын хилийн тодорхой хэсэгт хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх чиг үүрэг бүхий Монгол Улсын хилийн төлөөлөгч /цаашид “хилийн төлөөлөгч"

гэх/. түүний орлогчийг улсын хил хамгаалах байгууллагын дарга томилно[1] өөрөөр хэлбэл хилийн асуудлаар байгуулсан гэрээ. хэлэлцээрээр тогтоосон дэглэмийг сахиулах. улсын хил дээр зөрчил, будлиан гарахаас сэргийлэх, хил дээр үүссэн хилийн аливаа асуудлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор хилийн цэргийн байнгын бүрэлдэхүүнээс тусгайлан томилогдсон офицеруудын хүчээр хил залгаа улсын хил хамгаалах байгууллагатай хамтран явуулж буй дипломат арга хэмжээг хилийн төлөөлөгчийн ажиллагаа гэх бөгөөд улс орны эрх ашгийг улсын хил дээр хамгаалах арга хэлбэрийн нэг юм.

Улсын хил гэдэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг газрын гадаргуу. усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг[1 2] хэлдэг.

Улсын хил бол дэлхий дахинд орших улс орнуудын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг зааглах бөгөөд тухай улс орны тусгаар тогтнол, бүрэн эрх, орших эс оршихтой холбогдсон, өөрийн гэсэн хууль зүй тогтолтой өвөрмөц үзэгдэл гэж үздэг.

Хилийн асуудлаар хил залгаа улсуудтай байгуулсан гэрээ хэлэлцээрүүдийг байгуулснаар улсын хилийн шугамын явалтыг тодорхой болгох, тогтоон тэмдэглэх арчлан хамгаалах, хилийн орчинд явагдах үйл ажиллагааг зохицуулж байгаагаар агуулга, ач холбогдол тодорхойлогддог гэж үзэж болох юм.

Олон улсын гэрээ гэдэг нь улс гүрэн хоорондоо, улс гүрний болон олон улсын байгууллага хоорондоо улс төр, цэрэг, худалдаа, эдийн засаг, соёл, нийгэм, хүний эрх, хууль зүйн тодорхой асуудлаар хэлэлцээ хийж, харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тогтоох, өөрчлөх, зогсоох талаар зөвшөөрөлцсөн тохиролцоог тодорхойлсон баримт бичиг[3] юм.

Хилийн төлөөлөгчийн албаны үйл ажиллагааны зохион байгуулалтыг Монгол Улсын Хилийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 7-9 дэх заалтуудад тогтоож өгсөн. Үүнд:

- Хилийн төлөөлөгч нь хил залгаа улсын хилийн төлөөлөгчтэй Монгол Улсын олон улсын гэрээнд заасан арга хэлбэрээр хамтран ажиллана.
- Хилийн төлөөлөгч хэлэлцээ хийж, шийдвэрлэх шаардлагагүй гэж үзсэн асуудлыг хилийн төлөөлөгчийн орлогч, туслагчийн уулзалтаар шийдвэрлэнэ.

[1] Хилийн тухай хууль. 23 дугаар зүйлийн 23.1. //Төрийн мэдээлэл УБ., 2017. №6.
[2] Хилийн тухай хууль. 4 дүгээр зүйлийн 4.1. //Төрийн мэдээлэл УБ. 2017. №6.
[3] www.mongolitoi.mn Монгол хэлний их тайлбар толь. УБ. 2016.

- Хилийн төлөөлөгчийн шийдвэрлэх боломжгүй асуудлыг дипломат шугамаар шийдвэрлэнэ.

- Хилийн төлоөлөгчийн албаны зааврыг улсын хил хамгаалах байгууллагын дарга батална.

- Хилийн төлөөлөгчийг албан үүргээ гүйцэтгэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

Мөн хилийн төлөөлөгч нь "‘Хил залгаа улстай хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу томилогдсон хилийн төлөөлөгч, орлогч, туслагч, орчуулагч, шинжээч нар албан үүргээ гүйцэтгэх үедээ олон улсын гэрээнд заасны дагуу тухайн улсын хамгаалалтад байж, халдашгүй эрх эдэлнэ[1] “ түүний халдашгүй дипломат эрхийг хуульчилсан.

Эндээс дүгнэхэд хилийн төлөөлөгчийн албаны үйл ажиллагаа нь олон улсын гэрээгээр тогтоож өгсөн арга хэлбэрээр явагддаг бөгөөд дипломат арга хэмжээг зайлшгүй судлан хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигддаг нь харагдаж байна.

Дипломат үйл ажиллагаа гэдэг нь:

1. Харь улстай харилцахын тулд буюу ямар нэг гэрээ хэлэцээ хийхээр улсаа төлөөлсөн этгээд, дипломат төлөөлөгч;

2. Нэг улс нөгөө улстай харилцах гадаад бодлого; дипломат бодлого[1] [2] гэж монгол хэлний тайлбар толинд тусгасан байна.

Улсын хилийг тогтоон тэмдэглэж олон улсын хэмжээнд баталгаажуулах явдал бол өвөрмөц маягийн дипломат ажиллагаа юм. Үүнийг хилийн дипломат ажиллагаа гэж нэрлэж болно.

Хилийн төлөөлөгчийн үйл ажиллагаа нь дипломат ажиллагааны нэг хэлбэр бөгөөд Монгол Улсын хил дээр улсынхаа болон ард түмнийхээ ашиг сонирхлыг хамгаалах өөрөөр хэлбэл улсын хилийн болон хил орчмын дэглэмийг хил орчмын нутаг дэвсгэрт сахиулах, хөрш зэргэлдээх улс орнуудтайгаа сайн хөршийн харилцаа тогтоох, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явдлаар илэрдэг онцгой үйл ажиллагаа юм.

Улс орнуудын хооронд харилцах нэг чухал хэрэглүүр дипломат арга хэмжээ бөгөөд хилийн төлөөлөгчийн албыг зохион байгуулахдаа дипломатын зарим төрлийн хэлбэрийг ашиглах нь зүйтэй юм. Дипломат арга хэмжээний агуулга хэлбэрийн хувьд санал санаачилга гаргасан, эсэргүүцэл илэрхийлсэн, анхааруулсан, байр сууриа илэрхийлсэн, мэдээллийн чанартай гэхчлэн олон хэлбэртэй байдаг байна.

[1] Хилийн тухай хууль. 23 дугаар зүйлийн 23.6. //Төрийн мэдээлэл. УБ. 2017. № 6.
[2] www.Ouery.mn. Толь УБ хот., 2009 он

Олон улсын харилцааны практикт нилээд өргөн хэрэглэгддэг хэв шинж тогтсон хэлбэрүүдэд ноот албан захидал. тунхаглал, албан мэдээ, коммунике меморамдум санамж бичиг зэрэг юм. Эдгээр хэлбэрүүдээс хилийн төлөөлөгчийн ажиллагааны хүрээнд албан захидал солилцдог бөгөөд албан мэдээ. санамж бичиг зэргийг ашиглаж болох юм. Уг баримт бичгүүд нь аль ч үед. зориулалт. ямар субъектын төлөвлснөөр ач холбогдол. цар хэмжээг нь тодорхойлогдог байна.

Дипломат баримт бичгийн зорилго чиглэлээс шалтгаалж түүний агуулга, уг хэллэг нь янз бүр байх бөгөөд тухайн асуудал урьд өмнө нь ямар нэг байдлаар хөндөгдсөн. тухай салбарт ажиллагсдын мэдлэг. туршлага, сургамжтай холбоотойгоор тухайн асуудал, хэрэг явдал урьд өмнө нь ямар байдалтай байсан, түүнд талууд хэрхэн хандсан, асуудлыг бүрэн баримтжуулсан эсэх гэх мэт лавлагаа чухал шаардлагатай байдаг. Ялангуяа баримт сэлт бодит үндэслэлтэй, нотолгоотой байж, хүнд илтгэл үнэмшил төрүүлж түүний сэтгэл зүйд нөлөөлөхүйц байхаас бус нотлох баримтгүй, хөнгөн хийсвэр хандсан, үгээр хөөцөлдсөн, гоомой байваас өмнөө тавьсан зорилгоо биелүүлж чадахгүй байдалд хүргэж болзошгүй юм.

Хилийн төлөөлөгчийн албаны удирдлага дараах байдалтай хөгжиж ирсэн байдаг.

1. 1950-1960 онд Аюулаас хамгаалах газрын харьяа орон нутгийн аюулгүй байдлын газар хэлтсийн дарга, ажилтнууд гүйцэтгэж байсан.

2. 1960-1992 НАХЯ-ын харьяа Хилийн ба дотоодын цэргийн удирдах газрын харьяа Монгол, Хятадын хилд Ховд, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Дорнодын хилийн ангийн захирагч нар, Монгол Оросын хилд /найрамдалд орны хил хязгаар нэрийн дор хил хамгаалалтыг зохион байгуулах ангиуд цөөн байсан/ Баян-Өлгий, Увс, Сэлэнгэ, Дорнод аймаг дахь хилийн ангийн захирагч нар хавсран гүйцэтгэж байсан.

3. 1992-1996 онд Хилийн цэргийн удирдах газрын харьяа хилийн ангийн захирагч нар

4. 1996-2000 онд Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн төлөөлөгчийн газар, хилийн ангийн захирагч нар

5. 2000-2017 онд Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хил хамгаалалтын хэлтэс, Олон улсын гэрээнд дурьдсан хилийн ангийн захирагч нар

6. 2017 оноос Хил хамгаалах ерөнхий газрын харьяа Хилийн алба. хилийн төлөөлөгчийн газар, Хилийн төлөөлөгчийн хэлтэс. Гадаад харилцаа. хамтын ажиллагааны хэлтэс. Олон улсын гэрээнд дурьдсан хилийн ангийн захирагч нар удирдан явуулж байна.

**Дүгнэлт:** Аливаа асуудлыг олон өнцгөөс хууль эрх зүйн үндэслэлтэй авч үзэх, байр сууриа чадварлаг илэрхийлэх, харилцагч талдаа ойлгомжтой болох нь хилийн төлөөлөгчийн албаны удирдлага зохион байгуулалтын гол хэрэгсэл болдог.

Цаашид хилийн төлөөлөгчийн албаны үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтад доорх асуудал тулгамдаж байна.

1. ХХЕГ-ын дарга, штабаас хилийн төлөөлөгчийн албыг удирдан. уулзалт хэлэлцээрийн төлөвлөгөөг батлах, уулзалт хэлэлцээрийн явцад хяналт тавих, үр дүнг гаргах гэх мэтчилэн үйл ажиллагааг нь чиглүүлж байна. Дээд шатны байгууллагын удирдлагын хэмжээний уулзалтуудын бэлтгэл хангах, баталсан протокол, санамж бичгийн хэрэгжилтэд гадаад харилцаа хамтын ажиллагааны хэлтэс хянадаг бол хилийн төлөөлөгчийн хэлтэс доод шатны уулзалтын бэлтгэл, явц үр дүнг хянадаг тул Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулиар хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нь хилийн зурваст гарсан гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хэрэг бүртгэх эрхтэй болсон. Иймд хилийн төлөөлөгчийн албаны бүрэлдэхүүний хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх
2. Хилийн төлөөлөгч нь улсын хил дээр улс орны болон иргэдийн эрх ашгийг хамгаалах, Монгол Улсын нэр хүндийг ямагт дээдлэх зүй ёсны шаардлага гардаг тул дипломат арга хэмжээнд сургах
3. Хилийн төлөөлөгчийн албанд орон нутгийн удирдлага, хууль хяналтын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, харилцан мэдээ мэдээллийг шуурхай солилцох нөхцлийг бүрдүүлэх
4. Хилийн төлөөлөгчийн бүрэлдэхүүний гадаад хэл /хятад, орос ХЭЛТЭЙ/-НИЙ мэдлэгийг дээшлүүлэх зэрэг болно.